“Албан журмын даатгагчдын холбоо ГҮТББ”-ын удирдлагад

СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 98220935, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2020.02.05 № 20/07
танай ________ -ны № ________ -т

*Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан*

Дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Албан журмын даатгагчдын холбоо ГҮТББ -ын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Албан журмын даатгагчдын холбоо ГҮТББ -ын 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Байгууллагаас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай *тайлагналгүй* санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай материаллагт тооцогддог.

ХҮНДЭТГЭСЭН,

Сүлд-Аудит ХХК

Ерөнхий Захирал, МНБ

Ч.Гүндсаар

## АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО ГҮТББ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 293,403,283.35 | 212,275,101.70 |
| 1.1.2 | Богино хугацаат хөрөнгө оруулалт | 16,428,598,896.39 | 21,983,200,458.32 |
| 1.1.3 | Авлага | 138,609,871.58 | 134,947,289.00 |
| 1.1.4 | Бараа материал | 4,182,190.00 | 5,728,940.00 |
| 1.1.5 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 50,205,705.00 | 3,338,989.00 |
| 1.1.20 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **16,914,999,946.32** | **22,339,490,778.02** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө (Газар Барилга) | 1,663,000,000.00 | 1,663,000,000.00 |
| 1.2.2 | Хуримтлагдсан элэгдэл | (21,637,920.30) | (63,184,465.05) |
| 1.2.3 | Үндсэн хөрөнгө (Тээврийн хэрэгсэл) | 465,500,000.00 | 692,700,000.00 |
| 1.2.4 | Хуримтлагдсан элэгдэл | (229,142,585.39) | (288,369,341.02) |
| 1.2.5 | Үндсэн хөрөнгө (Компьютер, тоног төхөөрөмж) | 444,327,673.14 | 453,342,039.22 |
| 1.2.6 | Хуримтлагдсан элэгдэл | (245,682,315.02) | (315,809,860.31) |
| 2.3.20 | Үндсэн хөрөнгө (Тавилга эд хогшил) | 165,457,041.19 | 179,788,541.86 |
| 1.2.8 | Хуримтлагдсан элэгдэл | (62,504,434.54) | (76,357,284.83) |
| 1.2.11 | Биет бус хөрөнгө | 576,903,284.00 | 724,403,284.00 |
| 1.2.12 | Хуримтлагдсан элэгдэл | (227,763,574.77) | (315,022,304.56) |
| **1.2.20** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **2,528,457,168.31** | **2,654,490,609.31** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **19,443,457,114.63** | **24,993,981,387.33** |
| 2 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | |
| 2.1 | **ӨР ТӨЛБӨР** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | | |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 770,400.00 | |
| 2.1.1.6 | Татвар хураамжийн өглөг | | 1,322,719.60 |
| 2.1.1.10 | Бусад өглөг | 19,035.66 | 1,015,870.15 |
| **2.1.1.20** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **789,435.66** | **2,338,589.75** |
| 2.1.2 | **Урт хугацаат өр төлбөр** | - | - |
| 2.1.2.2 | Урт хугацаат зээл | - | - |
| 2.1.2.20 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - |
| **2.2.20** | **Өр төлбөрийн нийт дүн** | **789,435.66** | **2,338,589.75** |
| 2.3 | Цэвэр хөрөнгө | - | - |
| 2.3.1 | Нөөц: а) хязгаарлалтгүй | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 2.3.2 | б) хязгаарлалттай | 19,399,553,710.31 | 24,949,512,606.34 |
| 2.3.3 | Цэвэр хөрөнгө өмчийн бусад хэсэг | 33,113,968.66 | 32,130,191.24 |
| 2.3.4 | Хуримтлагдсан үр дүн | | |
| 2.3.8.1 | Тайлангийн үеийн | | |
| **2.3.20** | **Эздийн өмчийн дүн** | **19,442,667,678.97** | **24,991,642,797.58** |
| **2.5.20** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **19,443,457,114.63** | **24,993,981,387.33** |

*/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно/*

# АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО ГҮТББ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН 2019 ОНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

( төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны орлого** | | |
| 1.1 | Гишүүдийн татвар | | |
| 1.2 | Хөтөлбөр, төслийн орлого | | |
| 1.6 | Жолоочийн даатгалын сангийн эх үүсвэр | 6,802,896,306.90 | 6,882,768,268.41 |
| | **Үйл ажиллагааны орлогын дүн** | **6,802,896,306.90** | **6,882,768,268.41** |
| 2 | **Үндсэн үйл ажиллагааны зардал** | | |
| 2.1 | Бэлэг, хандив ба тусламж | | |
| 2.1.1 | (а) Байгууллагад өгсөн хандив, тусламж | | |
| 2.1.2 | (б) Хувь хүнд өгсөн хандив, тусламж | | |
| 2.1.3 | (в) Хандив, тусламж хүргэхтэй холбоотой гарсан зардал | | |
| 2.2 | Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал | | |
| 2.3 | Төсөл хэрэгжүүлсний зардал | | |
| 2.4 | Ерөнхий удирдлагын зардал | | |
| 2.4.1 | Цалин хөлс, шагнал | 393,368,653.00 | 562,031,547.00 |
| 2.4.2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 44,846,019.07 | 68,186,801.96 |
| 2.4.3 | Засвар үйлчилгээний зардал | 14,718,680.00 | 23,559,540.00 |
| 2.4.4 | Ашиглалтын зардал | 14,156,227.00 | 35,863,875.90 |
| 2.4.5 | Түрээсийн зардал | 131,552,267.00 | 89,674,842.77 |
| 2.4.6 | Албан томилолтын зардал | 13,992,598.00 | 6,352,090.00 |
| 2.4.7 | Даатгал, оношлогоо, татвар | 2,583,610.00 | 12,548,980.00 |
| 2.4.8 | Элэгдлийн зардал | 203,765,127.78 | 277,045,915.76 |
| 2.4.9 | Зар сурталчилгааны зардал | 87,637,000.00 | 102,705,788.40 |
| 2.4.10 | Шуудан, холбооны зардал | 18,814,982.88 | 30,100,023.51 |
| 2.4.11 | Шатахууны зардал | 6,235,887.00 | 10,495,289.00 |
| 2.4.15 | Бусад зардал | 102,028,443.44 | 114,309,661.98 |
| | **Үндсэн үйл ажиллагааны нийт зардлын дүн** | **1,033,699,495.17** | **1,332,874,356.28** |
| | **Үндсэн үйл ажиллагааны үр дүн** | **5,769,196,811.73** | **5,549,893,912.13** |
| 3 | Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) | 11,172,443.68 | (918,793.52) |
| 3.1 | Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг (алдагдал) | 11,172,443.68 | (983,777.42) |
| 3.2 | Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал) | | |
| 3.4 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | 64,983.90 |
| 3.5 | Татварын зардал | | |
| 3.6 | Бусад олз (гарз) | | |
| 4 | Онцгой шинжтэй зүйлс (цэвэр дүнгээр) | | |
| | **ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН** | **5,780,369,255.41** | **5,548,975,118.61** |

*/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно/*

SULD-AUDIT СҮЛД-АУДИТ ХХК

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН**
**ХОЛБОО ГҮТББ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН**
**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | Хязгаарлалттүй нөөц | Хязгаарлалттай нөөц | Цэвэр хөрөнгө өмчийн бусад хэсэг | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл** | **10,000,000.00** | **19,399,553,710.31** | **33,113,968.66** | **19,442,667,678.97** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| Залруулсан үлдэгдэл | 10,000,000.00 | 19,399,553,710.31 | 33,113,968.66 | 19,442,667,678.97 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт /бууралт | | | | - |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт /бууралт | | | | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн цэвэр үр дүн | | 5,549,958,896.03 | (983,777.42) | 5,548,975,118.61 |
| **2019 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл** | **10,000,000.00** | **24,949,512,606.34** | **32,130,191.24** | **24,991,642,797.58** |

*/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно/*

# АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО ГҮТББ-ЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2020 оны 2 дугаар сарын 6-ны өдөр Улаанбаатар хот

Менежментийн захидал

Сүлд- Аудит ХХК нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг "Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгдлэг АБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

***Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв.***

"Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ-ын 2019 оны санхүүгийн тайланд 1 зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан захирал Д.Цэвээнжав, Ахлах нягтлан бодогч Б.Соёлмаа болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж, аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв.

***<u>1. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцсон талаар</u>***

***Бодит байдал***

Өөрийн байгууллагын онцлогт тохирсон үндсэн хөрөнгийн ангилалд ашиглах хугацааг гаргаж баталж мөрдүүлээгүй, татварын хуулийн дагуу үндсэн хөрөнгөнд 189,787.2 мянган төгрөгийн элэгдлийг тооцож элэгдлийн зардал болгосон нь байна.

СҮЛД-АУДИТ ХХК

***Зөвлөмж***

НБББББ-т үндсэн хөрөнгийн цаашид ашиглах жилийг тооцон гаргаж, Удирдах зөвлөлөөрөө батлуулж мөрдөх хэрэгтэй.

**ТАНИЛЦСАН**

**СҮЛД-АУДИТ ХХК-ийн Аудитын багийн бүрэлдхүүн**

Захирал, Партнер Ч.Гүндбаяр

Аудитор Б.Долгорсүрэн
Туслах аудитор Г.Баяржаргал

***АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО ГҮТББ***

Гүйцэтгэх Захирал Д.Цэвээнжав

Ахлах ня-бо Б.Соёлмаа

**СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН АУДИТЫН АЖЛЫН БАГ**

СҮЛД-АУДИТ ХХК